

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.05.26

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Лхагва гарагийн үдээс хойш хувьцааны зах зээл болон АНУ-ын төрийн үнэт цаасны ханш огцом буурсан нь 20 жилийн хугацаатай Засгийн газрын бондын дуудлага худалдаа хүлээлтээс сул дүнтэй гарсантай холбоотой байв.
- Баасан гарагт Ерөнхийлөгч Трамп Европын Холбооноос импортлох бараа бүтээгдэхүүнд 50 хувийн тариф оноохоо зарласны дараа хувьцааны зах зээл үргэлжлүүлэн уналаа. Тэрбээр энэ арга хэмжээг зургадугаар сарын 1-нээс эхлүүлнэ гэж мэдэгдсэн бөгөөд хэлэлцээ “аль ч чиглэлд ахихгүй байна” хэмээн тайлбарласан.
- Түүнчлэн Apple компанийн iPhone утасны үйлдвэрлэлийг АНУ руу шилжүүлээгүй тохиолдолд 25 хувийн нэмэлт тариф ногдуулна гэж сүрдүүлсэн нь уг компанийн хувьцаа зөвхөн баасан гарагт 3 гаруй хувиар унахад хүргэжээ.
- Эдийн засагчдын үзэж буйгаар Хятад улс АНУ-ын тарифын нөлөөг сааруулахад хангалттай төсөв, нөөцтэй бөгөөд бодлогын нөлөөллийг ажиглаж байгаад шат дараалсан санхүүгийн тэлэлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүрэн бололцоотой гэж үзэж байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.05.19-05.25

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТИЙН ЭРЧ СААРЧ ЭХЭЛЛЭЭ.

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд өнгөрсөн долоо хоногт уналттай хаагдлаа. Жижиг, дунд компаниудын хувьцаа хамгийн их буурчээ. Харин технологид суурилсан Nasdaq Composite индекс харьцангуй тогтвортой байж чадсан ч 2.47%-иар унажээ. АНУ-ын хөрөнгийн зах зээл Дурсгалын өдрийг тохиолдуулан даваа гарагт амарна. Хэдийгээр долоо хоногийн эхний хагаст харьцангуй тайван байсан ч лхагва гарагийн үдээс хойш хувьцааны зах зээл болон АНУ-ын төрийн үнэт цаасны ханш огцом буурсан нь 20 жилийн хугацаатай Засгийн газрын бондын дуудлага худалдаа хүлээлтээс сул дүнтэй гарсантай холбоотой байв. Үүний үр дүнд урт хугацааны өгөөж өсч, 30 жилийн бондын өгөөж 2023 оноос хойших дээд түвшинд хүрсэн. Долоо хоногийн сүүлчээр бүх бондуудын үнэ бага хэмжээгээр сэргэсэн юм. (Бондын үнэ ба өгөөж эсрэг чиглэлтэй хөдөлдөг.)

Дуудлага худалдаа болон өгөөжийн өсөлт нь өнгөрсөн долоо хоногийн төгсгөлд зээлийн үнэлгээний Moody's агентлаг АНУ-ын төрийн өрийн үнэлгээг бууруулсантай холбоотой байж магадгүй хэмээн шинжээчид үзэж байна. Moody's агентлагийн энэ шийдвэр нь АНУ-ын төсвийн алдагдал болон өрийн түвшин нэмэгдэх эрсдэлтэйг онцолсон юм. Энэ нь долоо хоногийн сүүлчээр Төлөөлөгчдийн танхим Ерөнхийлөгч Дональд Трампын татварын шинэ хуулийг баталсантай зэрэгцэн өрийн түвшин цаашид ч өсөж болзошгүй гэсэн болгоомжлолыг улам лавшруулсан бололтой. Баасан гарагт Ерөнхийлөгч Трамп Европын Холбооноос импортлох бараа бүтээгдэхүүнд 50 хувийн тариф оноохоо зарласны дараа хувьцааны зах зээл үргэлжлүүлэн уналаа. Тэрбээр энэ арга хэмжээг зургадугаар сарын 1-нээс эхлүүлнэ гэж мэдэгдсэн бөгөөд хэлэлцээ "аль ч чиглэлд ахихгүй байна" хэмээн тайлбарласан. Түүнчлэн Apple компанийн iPhone утасны үйлдвэрлэлийг АНУ руу шилжүүлээгүй тохиолдолд 25 хувийн нэмэлт тариф ногдуулна гэж сүрдүүлсэн нь уг компанийн хувьцаа зөвхөн баасан гарагт 3 гаруй хувиар унахад хүргэжээ.

50%-ИЙН ТАРИФЫГ 7 САР ХҮРТЭЛ ХОЙШЛУУЛАВ

Харин амралтын өдрүүдэд ЕХ ногдуулах тарифын хэрэгжилтийг дахин нэг сараар сунгав. Даваа гарагийн өглөө АНУ-ын хувьцааны фьючерсүүд мэдэгдэхүйц өсөлттэй эхэллээ. Үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйл бол ерөнхийлөгч Дональд Трамп Европын холбоонд ногдуулах 50%-ийн импортын тарифыг долдугаар сарын 9 хүртэл хойшлуулна хэмээн мэдэгдсэн явдал байв. Трамп ЕХ-ны тэргүүн Урсула фон дер Лайентай утсаар ярьсны дараа тарифын асуудлыг түр хойшлуулж, худалдааны хэлэлцээг нэн даруй эхлүүлэхээр тохирсон гэж мэдэгдэв. Энэ нь зах зээлд тодорхой хэмжээний тогтвортой байдлыг авчирч, хөрөнгө оруулагчдын эрсдэлээс зайлсхийх хандлагыг сүлрүүлсэн үзэгдэл боллоо.

Дэлхийн бондын зах зээл хямарч, АНУ болон Японы урт хугацаат бондын өгөөж огцом өсөж ханш нь унаж байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчид уламжлалт аюулгүй хөрөнгөөс зугтаж, Bitcoin руу хандаж эхэллээ. АНУ-ын 30 жилийн бондын өгөөж 5.15%-д хүрч, 36.8 их наяд долларын өрийн хүүгийн дарамт улам нэмэгдэж байна. Төв банк бодлогын хүүг бууруулах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэх алхам хийхээс зайлсхийж байгаа нь зах зээлд итгэл сүлрүүлэх шалтгаан болж байна. Японд ч мөн ижил нөхцөл үүсч, бондын өгөөж 1999 оноос хойших дээд түвшинд хүрч, ерөнхий сайд өрийн байдал Грекийнхээс дор байгааг хүлээн зөвшөөрсөн. Ийм нөхцөлд Bitcoin улам эрэлттэй болж, институциональ хөрөнгө оруулагчид уламжлалт хувьцаа, бондоос илүүтэй Bitcoin-ийг аюулгүй, улс төрөөс ангид үнэ цэнэтэй хөрөнгө гэж үзэх хандлага нэмэгдэж байна. Bitcoin ETF-ийн нийт хөрөнгө 104 тэрбум долларт хүрч, үнэ нь улам нэмэгдэх таатай орчин бүрдэж байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.05.19 – 05.25

ХЯТАДЫН ЭЗ ҮЗҮҮЛЭЛТҮҮД СААРЧ БАЙНА.

Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл түр хугацаанд АНУ-тай байгуулсан худалдааны түр эвлэрлийн дараа бага зэрэг сэргэсэн. Гэхдээ эдийн засгийн бодлого руу анхаарал чиглэж эхэлснээр бууралттай хаагдлаа. FactSet-ийн мэдээллээр, дотоодын CSI 300 индекс 0.18%-иар, Шанхайн нийлмэл индекс 0.57%-иар буурсан бол Хонконгийн Hang Seng индекс эсрэгээрээ 1.10%-иар өсжээ.

АНУ-тай үүссэн худалдааны хурцадмал байдлын дараах Хятадын эдийн засгийн нөхцөл байдлыг харуулсан гурван гол үзүүлэлт нийтэд танилцуулагдлаа. Үүнд:

- Аж үйлдвэрийн үйлдвэрлэл 4-р сард жилийн харьцуулалтаар 6.1%-иар өссөн нь шинжээчдийн хүлээлтээс давсан дүн байв.
- Бөөний худалдааны орлого, хэрэглээний гол үзүүлэлт, 3-р сард 5.9% байсан бол 4-р сард 5.1% болж саарсан нь эдийн засагчдын таамаглалын доогуур гарсан.
- Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт (барилга, дэд бүтэц зэрэг багтана) нэгдүгээр сараас дөрөвдүгээр сарын хооронд 4%-иар өссөн ч хүлээлтээс доогуур байсан бөгөөд үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын огцом бууралтаас шалтгаалжээ.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн гэнэтийн өсөлт нь АНУ-ын эхлүүлсэн худалдааны дайны улмаас Хятадын эдийн засаг шууд уналтад орохоос сэргийлж чадсан болохыг харуулж байна. Гэвч хэрэглээний өсөлтийн саарсан хандлага нь олон эдийн засагчдын анхааруулж байснаар Бээжин иргэдийн итгэлийг сэргээхийн тулд илүү идэвхтэй хэрэглээ дэмжих бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Эдийн засагчдын үзэж буйгаар Хятад улс АНУ-ын тарифын нөлөөг сааруулахад хангалттай төсөв, нөөцтэй бөгөөд бодлогын нөлөөллийг ажиглаж байгаад шат дараалсан санхүүгийн тэлэлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүрэн бололцоотой гэж үзэж байна.

NVIDIA ХЯТАД ЗАХ ЗЭЭЛД ЗОРИУЛЖ ХЯМД BLACKWELL AI ЧИП ГАРГАНА

Nvidia компани АНУ-ын экспортын хязгаарлалтыг тойрон Хятадын зах зээлд байр сууриа хадгалах зорилгоор хямд үнэтэй шинэ Blackwell AI чип гаргахаар боллоо. Энэхүү чип нь өмнөх H20 загвараас хямд буюу 6,500–8,000 ам.долларын үнэтэй байх бөгөөд илүү сүл үзүүлэлттэй, үйлдвэрлэл хялбар бүтэцтэйгээр 6-р сард үйлдвэрлэл нь эхлэх төлөвтэй байна. HBM өндөр хурдны санах ой оронд GDDR7 ашиглаж, TSMC-ийн дэвшилтэт савлагааны технологийг хэрэглэхгүй байгаа нь АНУ-ын шинэ хязгаарлалтуудтай нийцэж байгаа юм.

АНУ-ын экспортын хатуу хяналтын улмаас Nvidia өмнө нь тусгайлан Хятадад зориулж гаргасан H20 чипээ борлуулж чадаагүй бол энэ удаагийн шинэ загвар нь хязгаарлалтад өртөхгүйгээр зах зээлд нийлүүлэх зорилготой. Nvidia-ийн гүйцэтгэх захирал Женсен Хуанг Хятадыг 50 тэрбум ам.долларын үнэ цэнтэй зах зээл гэж үзэж байгаагаа илэрхийлсэн бөгөөд экспортын хориг нь урвуу нөлөө үзүүлж, Хятадын дотоодын чип үйлдвэрлэгчид, тэр дундаа Huawei-ийн Ascend цувралтай өрсөлдөх нөхцөл бүрдүүлж байна гэж мэдэгджээ. Nvidia-ийн Хятадын зах зээлд эзлэх хувь 2022 онд 95% байсан бол өнөөдөр 50% болж буурсан нь энэ шинэ стратеги яаралтай хэрэгжих шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning May 19, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
ZIM **** ZIM GILT	TCOM Trip.com	PHD PONY	PANW paloalto	TGT TARGET	SNOW snowflake	BJ B's	DECK DECKERS	BAH Boac Allen Hamilton	
CGEN Gilat	EGHT 8x8	TOL Toll Brothers	TOL Toll Brothers	BIDU Baidu	ZM zoom	ADI ANALOG DEVICES	ADSK AUTODESK	MNSO MINISO	
CGEN compugen	AGYS agilysys	BLU bilibili	TUYA tuya	TJX TJX	AMSC amsc	AAP Advance Auto Parts	INTU intuit		
OXLC OXFORD LANE	SB SAFEHOLDERS	VIR VIKING	MOD MODINE	VFC VF CORPORATION	URBN URBAN OUTFITTERS	LSPO lightspeed	ROSS ROSS DRESS FOR LESS		
OSL GLOBAL SHIP LEASE	TRNS TRANSCAT	CAN Canaan	KEYS KEYSIGHT TECHNOLOGIES	WIX WIX	DOMO DOMO	ATAT ATOUR GROUP	WDAY workday		
ICL ICL	GFN GIFU 奇富科技	AS AMER SPORTS	SKY SKYLINE CHAMPION	MDT Medtronic	BBVA BBVA	CSW CSW INDUSTRIALS	CPRT Copart		
CB 中比新能源		RENE 万物新生	XP XP Inc.	YMM 满帮 Full Truck Alliance	ENS EnerSys	RL RALPH LAUREN	SVM SILVERCORP MEDICAL INC.		
TH TARGET HOSPITALITY		VIP 唯品会	EARN EARN	KNOP KNOT Offshore Partners LP	RAMP LiveRamp	TD TD Bank	STEP STEPSTONE		
RYAAY RYANAIR		HTHT 华住世界	VST Viasat	LOW LOWE'S	CLIR ClearSign	WSM WILLIAMS-SONOMA	LION LIONSGATE		
		GDS GDS 万国数据	AUNA auna	DY DYCOM		THRM THERMON	PLUS ePlus Technology		
http://eps.sh/cal						© 2025 Earnings Whispers			

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning May 26, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
EH CHANG 亿航	HSAI HESAI	PDO Pinduoduo Inc.	OKTA okta	DKS DICK'S SPORTING GOODS	NVDA NVIDIA	FL Foot Locker	MVRL MARVELL	CGC CANOPY GROWTH	
	JOYY Jooyy	SKY CHAMPION HOMES	BOX box	ANF Abercrombie & Fitch	CRM salesforce	BEST BEST BUY	COST COSTCO WHOLESALE	SCVL SHOE CARNIVAL	
		BNS Scotiabank	API agora	KC Kingsoft Cloud	AI C3.ai	CAL CALERES	BELL DELL	TIGR UP Fintech 老虎證券	
		AZO AutoZone	SMTC SEMTECH	M macys	ELF elf	BURL Burlington	ESTC elastic	YTRA yatra	
		GLNG Golar LNG	SUPV GRUPO SUPERVIELLE	VNET 世纪互联	NUTANIX NUTANIX	FUTU FUTU	ZS zscaler	CRLBF CRESCOLABS	
		SHIP seanergy	HEI HEICO	CMCO COLUMBUS MCKINNON	S SentinelOne	KSS KOHL'S	ULTA ULTA BEAUTY		
		BLRX BIOLINEX	SQM SQM	BHR Phreesia	AGLT Agilent Technologies	HRL Hormel Foods	GAP Gap Inc.		
		DLNG DYNAGAS LNG Partners LP	GAL Grupo Galicia	CPRI CAPRI HOLDINGS LIMITED	VEEV Veeva	ROIV ROIVANT SCIENCES	AEQ AMERICAN EAGLE OUTFITTERS		
				BMO BMO	PSTG PURE STORAGE	LI 理想	AMBA Ambarella		
				EIC EAGLE POINT	SNPS synopsys	MOV MOYADO GROUP INC	PATH Path		
http://eps.sh/cal						© 2025 Earnings Whispers			